

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2016-7 САР)


Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2016 оны 7 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4,808 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

2016 оны 7 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 0.8%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 9.7%-иар тус тус буурчээ.


Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байгаа нь орон сууцны үнийн индексийг бууруулахад нөлөөлжээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



Жишээ: БЗД-ийн “Монгол” хотхонд 2015 оны 7 дугаар сард 1 м² дундаж үнэ 1,771,000 төгрөг байсан бол 2016 оны 7 дугаар сарын байдлаар 1,625,000 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.2%-иар буурсан байна.

1. Шинэ орон сууцны үнэ¹


Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2016 оны 7 дугаар сарын байдлаар 2,034,000 төгрөг болж өмнөх сараас 0.3 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 5.1 хувиар тус тус буурсан байна.

¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2016.7/


Орон сууцны дундаж үнэ	2,034,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-5.1%
Сарын өсөлтийн хувь	-0.3%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2016 оны 7 дугаар сарын байдлаар 77,466,000 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 14.7 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2016.7/


Орон сууцны дундаж үнэ	77,466,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-14.7%
Сарын өсөлтийн хувь	-0.8%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сар.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)